



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/64

Хужирт сум

Согтууруулах ундаа худалдаалах,
түүгээр үйлчлэхийг түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд 2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулагдахтай холбогдуулан согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгүүдийг 2023 оны 04 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг түр хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Алтансүх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

622301127

D:Alban bichig;Zahiramj 2023